



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Б.ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Өвөрхангай аймгийн  
Есөнзүйл сумын  
Цэцэрлэгийн  
Эрхлэгч Б.Эрдэнэцэцэг

Бүтэн жилийн  
Гүйцэтгэлийн  
Төлөвлөгөөний  
Биелэлт

2024 он

**ЕСӨН ЗҮЙЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Б.ЭРДЭНЭЦЭЦЭГИЙН  
2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2024.12.17

Д/д	Зорилтийг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Гүйцэтгэлийн хувь
<b>ЗОРИЛТ 1: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД</b>							
1.1	<u>Арга хэмжээ 1.1</u> Хууль тогтоомж, засгийн газар болон харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах		Хууль дүрэм тушаал шийдвэрүүд хэрэгжилтийн байдлаар	Шинээр гарсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	Хууль тогтоомжийн хэрэгжилт 100 хувьд хүргэнэ.	2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжсэн эрх зүйн бичиг баримттай танилцан, шинээр гарсан Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль тогтоомжуудыг уншиж судлан багш ажилчдад мэдээ мэдээллийг хүргэн ажиллсан. Монгол улсын засгийн газрын 107, 192 журам болон БШУС-н 128, 430 болон хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлтөд тулгуурлан өөрийн ажлын чиглэлд хэрэгжүүлэн ажиллаж байна. Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулгыг нийт 34 эцэг эх асран хамгаалагч, 14 багш ажилтанд танилцуулсан. Ёс зүйн дүрмийн тухай сургалтыг 2 удаа давхардсан тоогоор 33 багш ажилтанд танилцуулах сургалтыг зохион байгуулсан. Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний сургалтад 4 багш 3 удаа	90%

						хамаргдаж гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулан ажилласан. Хууль тогтоомжийн хэрэгжилт 100% хангаж ажилласан байна.	
1.2	<u>Арга хэмжээ 1.2</u> Боловсролын үйлчилгээг чанартай зохион байгуулахад Байгууллагын менежментийг сайжруулах, Байгууллагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт үр дүн		Хэрэгжилтийн эзлэх хувь	80 хувь 77	88 хувь 84	Байгууллагын стратеги төлөвлөгөөг 2025, боловсролын ерөнхий хууль, эрхэм зорилго, алсын хараа, үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан. Байгууллагын менежментийг сайжруулахын тулд багш ажилтны чадвар нөөц бололцоонд тулгуурлан ажлуудыг төлөвлөн үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Багш ажилтны цагийн менежментийг сайжруулан дотоод журамд тусгаж, хүүхдийн хөгжлийн үнэлгээний чанарыг сайжруулах ажил руу чиглэн үйл ажиллагааг явуулж байна.	90%
1.3	<u>Арга хэмжээ 1.3</u> Байгууллагын үйл ажиллагаанд БСШУСайдын А/803 дугаар тоот тушаалын хэрэгжилтийг хангах.		Сургалтын хөтөлбөр	Хичээлийн жилд	Сайжруулан боловсруулсан	БСШУСайдын А/803 дугаар тоот тушаалыг багш албан хаагчидад танилцуулан, үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна	70%

1.4	<u>Арга хэмжээ 1.4</u> 1.2.3.4 дүгээр багийн 5-н настай хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах. 6 настай хүүхдийг сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах				5 настай хүүхэд 100% сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн байна.	2022-2023 оны хичээлийн жилд 5 настай 44 хүүхдийн 22 нь тахимаар 11 хүүхэд хувилбарт сургаалтаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшсэн бол 2024-2025 оны хичээлийн жилд танхимаар 22 хувилбарт сургалтаар 6 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол олгон ажиллаж байна. Энэ нь нийт хамран сургах тойргийн хүүхдийн 65% эзэлж байна. Үлдсэн 35% хүүхэд өөр орон нутагт УБ хотод сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа.	90%
1.5	<u>Арга хэмжээ 1.5</u> Сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн Заах аргын нэгдэлтэй хамтран сургууль цэцэрлэгийн залгамж холбоог сайжруулах ажлыг зохион байгуулах.		Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо, үр дүнгээ		Эхний хагас жилд-1 Жилийн эцэст-2	Ерөнхий боловсролын сургуультай танилцах үйл ажиллагааг 5 настай хүүхдүүдийн дунд 1 удаа. Бага ангийн багшаас туршлага солилцох үйл ажиллагааг 1 удаа зохион байгуулсан. 5 настай хүүхдийг сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг ерөнхий боловсролын сургуультай хамтарч зохион байгуулж дүгнэлт хийсэн.	90%
1.6	<u>Арга хэмжээ 1.6</u> Албан хаагчдын монгол бичгийн чадварын түвшин тогтоож, үнэлгээнд суурилсан сургалт зохион байгуулна. Байгууллагаас гарч байгаа зарим баримт		Багш албан хаагчдын дунд зохион байгуулсан үйл ажилгааны хэрэгжилт, ахицаар		Багш албан хаагчдын Үндэсний монгол бичгийн чадвар ахисан байх, сургал сурталчилгааны	Төрийн байгууллагад албан хэрэг хөтлөлтийг хос бичгээр явуулах бэлтгэл хангах: 2025 онд албан бичгийг хос бичгээр хөтлөх болсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг хангахын тулд Үндэсний монгол бичгийн түвшин тогтоох	90%

	бичгүүдийг кирилл монголоор хослуулж гаргах				ажлын хэрэгжилтээр	<p>сорил цаасаар 1 удаа, цахимаар 2 удаа авч Чадвахжуулах сургалтыг зохион байгуулсан. Мөн монгол бичгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд 5 төрийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. Энэ үйл ажиллагаанд давхардсан тоогоор 35 хүн оролцсон.</p> <p>Мөн байгууллагын хэвлэмэл хуудсуудыг монгол бичгээр захиалан авч албан бичигтээ хэрэглэн ажиллаж байна. Бие даан сурах боломжийг бүрдүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Багшийн хөтөлбөл зохих зарим бичиг баримтыг үндэсний бичгээр боловсруулж ажиллаж байна</li> <li>- Хавтасны хаяг, багш албан хаагчдын хувийн хэргийн нүүр зэргийг үндэсний бичгээр бичсэн.</li> <li>-Эрхлэгч, багшийн туслах нар компьютер дээр бичих чадвараа бие даан ахиулан анхан шатны бичиг барим боловсруулах чадварт суралцсан.</li> </ul>	
1.7	<u>Арга хэмжээ 1.7</u> "Угийн бичиг" хөтлөх аян үргэлжлүүлэн хэрэгжүүлэх		Хийгдсэн байдлаар	-	Хүн бүр угийн бичиг хөтөлсөн байна	Угийн бичиг хөтлөх, түүний ач холбогдолын талаар сургалтыг 2 удаа давхардсан тоогоор 18 хүнд зохион байгуулсан. Сумын тамгийн газраас байгууллагуудын албан	70%

						хаагчдын дунд зохион байгуулсан угийн бичгийн уралдаанд 14 хүн оролцож бүлгийн багш Н.Долгоржав 3 дугаар байр эзэлсэн. Нийт багш ажилтан 100% угийн бичгээ хөтлөж байгаа	
1.8	<u>Арга хэмжээ 1.8</u> Шатар” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ		Суралцсан хүүхдийн тоо үр дүнгээр	-	3-5 настай хүүхдэд сургасан байна	Цэцэрлэг дээр шатрын дугуйланд 18 хүүхэд хамрагдсан байна.	70%
1.9	<u>Арга хэмжээ 1.9</u> Бага насны хүүхдийг жөндөрт, суурилсан элдэв хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нандин тойрог”-аянд нэгдэх.		Хэрэгжүүлсэн байдлаар	-	Хүүхэд хамгаалал, аяны заалт бүрээр хэрэгжүүлсэн байна	Өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд бага насны хүүхдийг жөндөрт, суурилсан элдэв хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлсэн.	90%
1.10	<u>Арга хэмжээ 1.10</u> Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, багшийн гүйцэтгэлийн үнэлгээг Боловсрол Шинжлэх ухааны яамны сайдын А/430, А/500 дугаар тушаалын дагуу үнэлгээг зохион байгуулах.		Гүйцэтгэлийн үнэлгээ өөрийн байгууллага дээрээ зохион байгуулсан байдлаар	-	Гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулсан байдлаар	Багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг журмын дагуу амжилттай зохион байгуулсан. Бүлгийн 1 багш урамшуулал авч байгаа	70%
1.11	<u>Арга хэмжээ 1.11</u> Байгалийн давагдашгүй хүчин зүйл, гамшиг, эрсдэлийн үе дэх дэглэмийг баримтлан, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллах		Хийсэн ажлын чанар хүртээмж үр дүнгээр	-	Гамшигаас хамгаалах төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан, хэрэгжүүлэн ажилласан байна	Гамшигаас хамгаалах бэлэн байдлын сургалтыг 2 удаа. Бэлэн байдлыг хангах дадлага сургуулалтад 1 удаа хамрагдсан байна. 2-5 настай хүүхдүүдийн дунд гамшгийн үеийн бэлэн байдалд өөрийгөө хамгаалах болон аюул эрсдлээс өөрийгөө	100%

						хэрхэн хамгаалах урьдчилан сэргийлэх талаар Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хөтөлбөр төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэн ажиллаж байна.	
1.12	<u>Арга хэмжээ 1.12</u> Дээд шатны байгууллагууд болон сумын засаг даргаас өгсөн хугацаатай үүрэг даалгавар, тайлан мэдээ, албан бичгийн хариуг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан хугацаанд нь хүргүүлэх		Тухай бүр хугацаанд нь хүргүүлсэн байдал, албан бичгийн стандартыг мөрдөж ажилласан байдлаар	-	Хэрэгжүүлэн ажиллаж байна	ЗГ-н 100 дугаар тогтоолын хавсралт, болон бусад хөтлөх баримт бичгийн жагсаалтыг боловсруулахлаа 100 хувь албан бичгийн стандартын дагуу боловсруулсан байна.	90%
1.13	<u>Арга хэмжээ 1.13</u> Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэнэ		Хуульд заасан хугацаанд шуурхай, хүнд суртал, чирэгдэлгүй шийдвэрлэж хариу өгсөн байдлаар	-	Хуулийн хугацаанд хэрэгжүүлэн ажиллаж байгаа	Нийт 18 өргөдөл гомдол ирснээс ажилд орохыг хүссэн 10 чөлөө хүссэн 8 ур чадварын нэмэгдэл авахын хүссэн 1 өргөдөл ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн байна.	100%
1.14	<u>Арга хэмжээ 1.14</u> Байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем ( <a href="https://erp.e-mongolia.mn/">https://erp.e-mongolia.mn/</a> )-ийг нэтрүүлэх, мэдээлэл солилцооны дундын системд холбогдох ажлыг эрчимжүүлэх		Байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем ( <a href="https://erp.e-mongolia.mn/">https://erp.e-mongolia.mn/</a> )-ийг нэтрүүлсэн байна	-	-	Цахим шилжилтийн жилийн ажлын хүрээнд байгууллага интернэт шилэн кабелд холбогдсон. E-report.mof.gov.mn F-huulga.mof.gov.mn Etax.mta.mn Portal.ndaatgal.mn Payroll.gov.mn Shilendans.gov.mn E-invoice.ebarimt.mn	100%

						Mecs.dynamic.mn Esis ХНУТМ программууд дээр ажиллаж байна	
1.15	<u>Арга хэмжээ 1.15</u> Байгууллагын мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах, "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг ханган ажиллана		Хууль, тогтмоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	-	"Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын тухай сургалтын "Насан туршийн боловсролын төвийн багш Д.Даваажаргал 1 удаа сургалт зохион байгуулж боршур гарын авлага тараасан нийт 14 багш ажилтан хамрагдсан байна. Хандлага зөрчил гаргаагүй	90%
1.16	<u>Арга хэмжээ 1.16</u> Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг тогмол шинэчилж, мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт нууцлалыг хангаж ажиллах		Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байна Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үүрэгжүүлсэн байдал		Үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна.	"Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам"-ыг 100 хувь мөрдөж цаг тухай бүр мэдээлэл үнэн зөв байршуулж ажилласан Багш ажилтны ажилд орсон гарсан цалин урамшуулал нэмэгдэл боловсролын байдал зэрэг мэдээ мэдээллийг оруулж хувь хүний болон албан байгууллагын нууцыг чанд мөрдөж ажилласан.	100%
1.17	<u>Арга хэмжээ 1.17</u> Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг сурталчлан таниулах, сургалт хийх, ёс зүйн дэд хороог байгуулах		Төрийн албан хаагчийн ёс зүйн хороог байгуулан хийж хэрэгжүүлсэн ажлын тоо, үр дүнгээр		Хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан	Байгууллагын ёс зүйн дэд хороог 2024 оны 02 дугаар сарын 04 ний өдрийн эрхлэгчийн А\03 дугаар тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ерөнхий боловсролын сургууль, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын	100%



						багш ажилтны Ёс зүйн шинэчилсэн дүрмийг танилцуулах сургалтыг 3 удаа давхардсан тоогоор 37 хүнд тус тус зохион байгуулсан. Ёс зүйн зөрчил гэж юу? Хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Зөрчил гарсан тохиолдолд сахилга хариуцлага тооцох журам зэрэг тогтмол мэдээ мэдээлэл өгөхөөс гадна байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулан улирал бүр шаардлагатай тохиолдолд тухай бүр хийхээр төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна.	
1.18	<u>Арга хэмжээ 1.18</u> Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тайлагнах. Цахим хуудсанд байршуулан мэдээлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар		Үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан.	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн хор уршиг сургалтыг 2 удаа 10 хүнд зохион байгуулсан. Аливаа төрлийн ашиг сонирхолын зөрчил гаргаагүй ажилласан. Ажилтан авахад удирдах дээд шатны байгууллагад мэдэгдэж зохиох журмын дагуу зохион байгуулан аливаа төрлийн ашиг сонирхлын зөрчил гаргаагүй ажилласан.	90%
<b>ЗОРИЛТ 2: СУРАЛЦАГЧ, ИРГЭНД ХҮҮХДЭД ТЭГШ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>							
2.1.	<u>Арга хэмжээ 2.1</u> Багш солилцоо явуулах, туслах багш нарын туршлага солилцоо хийж бусад багш нартай		Удирдамжид заагдсан төлөвлөгөөт ажлуудаар			Бүсийн арга хэмжээнд 5 дугаар сард 14 багш ажилтан хамрагдаж туршлага солилцох хийж хэрэгжүүлж буй ажлаа	100%

	хамтран ажиллах, арга зүй туршлагаас суралцах					суртачлах, түгээн дэлгэрүүлэх ажлыг 1 удаа Мэргэжлийн хөгжлийн бүлгээр ажиллах ажлын чиглэл гаргах төлөвлөгөө боловсруулах ажлаар бүсийн багш нартай уулзсан уулзалт хэлэлцүүлэгт 4 бүлгийн багш 1 эрхлэгч хамрагдан цаашид ажиллах үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна. Арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэгийн туршлага судлах үйл ажиллагааг 1 өдөр зохион байгуулсан энэ үйл ажиллагаанд эрхлэгч 1, бүлгийн 4 багш хамрагдсан	
2.2	<u>Арга хэмжээ 2.2</u> Дугуйлан, хөгжүүлэх сургалт / Шатар, спорт өрөлт, могой шоо, даам, монгол ардын уяа зангилаа, гэх мэт/ үйл ажиллагааг идэвхжүүлж, хагас бүтэн жилээр Хүүхэд бүрийг оролцуулъя. Хамтдаа хөгжье тайлант өдөрлөг зохион байгуулна. Хичээллүүлж байгаа дугуйлан секц бүр дээр хүүхдүүдийн дунд тэмцээн зохион байгуулна.		5-н хөгжүүлэх сургалт хичээллүүлж 70 хүүхэд хамруулна		2024 онд Дугуйлан хичээллүүлж 5-н сард хүүхэд бүрийг оролцуулан тайлан тоглолт зохион байгуулсан.	Хүүхэд хөгжүүлэх дугуйланг төлөвлөгөөний дагуу зохион байгуулан 1 удаа тайлан тавьсан энэ үйл ажиллагаанд 63 хүүхэд хамрагдсан. 2024 оны 09 дүгээр сарын 1-ний өдрөөс Бүжиг Шатар Спорт өрөлт Наамал төрлөөр хүүхэд хөгжүүлэх дугуйланг төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулан ажиллаж байна энэ үйл ажиллагаанд нийт 53 хүүхэд хамрагдаж байна.	90%

2.3	<u>Арга хэмжээ 2.3</u> Багш нарын ур чадвар, “Шилдэг илтгэл”-ийн уралдааныг зохион байгуулах багш нарын мэдлэг ур чадварыг өсгөх		Багш нарт гарсан ахиц, өөрчлөлт, амжилтаар		Илтгэлийн уралдаанд-4 багш	10-11 дүгээр сард хийхээр төлөвлөсөн. Одоогоор хэрэгжээгүй байна	0%
2.4	<u>Арга хэмжээ 2.4</u> “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана		Багшийн хөгжил хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр		2023 онд 4-н багш багшийн хөгжил хөтөлбөрийн арга хэмжээний хүрээнд төлөвлөгөө гарган ажилласан хэрэгжилт 60%.	Бүлгийн 4 багш өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө гарган ажилласан. Туршлага судлах үйл ажиллагаа арвайхээр сумын 7 дугаар цэцэрлэгт 1 удаа 4 багш, 1 эрхлэгч, бүсийн арга хэмжээнд 3 удаагийн арга хэмжээнд 4 багш 1 эрхлэгч давхардсан тоогоор 21 албан хаагч хамрагдсан хамрагдсан байна	90%
<b>ЗОРИЛТ 3: ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛАЛ, ОРОЛЦООГ ДЭМЖИХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>							
3.1	<u>Арга хэмжээ 3.1</u> Хүүхэд бүр ижил тэгш үйлчлэх, хүүхэд нэг бүр ээлтэй тухтай орчин бүрдүүлэх		Төлөвлөсөн ажлын хувиар		2023 онд төлөвлөгөөнд тусгагдсан ажил 85 хувьтай хэрэгжсэн	Хүүхэд бүр ижил тэгш үйлчлэх аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтын хэлбэр үүсгээгүй ажилласан Хүүхдэд ээлтэй орчин чимээгүй амрах төв номын булан байгуулах уралдаан 10 дугаар сард зохион байгуулан 4 бүлэг амжилттай оролцсон Нийт 68 ном гарын авлага, буйдан зэрэг 800000 гаруй төгрөгийн хэрэглэлийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуулан хийсэн	90%

						Хүүхдийн тоглоомын талбайн засвар үйлчилгээ, аюулгүй байдалд тогтмол хяналт тавихаас гадна камер хяналтын төлөвлөгөө хувиар боловсруулан хяналт шалгалт тавьж ажилласан.	
3.2	<u>Арга хэмжээ 3.2</u> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт сурах хамруулах боломжийг бүрдүүлнэ		Хамрагдах гэж ирсэн хүүхдийн тоогоор		2023 онд эмчийн магадалгаатай хүүхэд байхгүй.	Одоогоор хэрэгжээгүй (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүртгэгдээгүй )	0%
3.3	<u>Арга хэмжээ 3.3</u> Цэцэрлэгийн захиргаа, багш, эцэг эхийн гуравласан гэрээг шинээр элссэн хүүхдийн эцэг эхтэй байгуулж ажиллана		Гүйцэтгэлийн хувиар болон гэрээнд оруулсан өөрчлөлтийн хэрэгжилтийн хувиар	Жилдээ	60%	100% гэрээ байгуулан, гэрээний үр дүнг тооцож ажиллаж байна Шинээр элсэн орсон 15 хүүхдийн эцэг эх асран хамгаалагчидтай гурвалсан гэрээ байгуулсан.	100%
3.4	<u>Арга хэмжээ 3.4</u> Хүүхэд хамгааллын ажлыг сайжруулах эрчимжүүлэх ажлын хүрээнд багш ажилчид, эцэг эхийн зөвлөл, эцэг эхтэй хамтран зорилтод бүлгийн хүүхдүүд рүү чиглэсэн ажил зохион байгуулах.		Судалгаанд үндэслэнэ.		2023 онд 2 хүүхдэд дэмжлэг үзүүлсэн	2024 онд дэмжлэг үзүүлэх шаардлагатай 1 хүүхдүүдийг холбогдох байгууллагуудтай зуучлан тэдний асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Шинээр гарсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн танилцуулгыг эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл 43 хүн, багш ажилтан 14 хүнд зохион байгуулсан. Цэцэрлэгийн орчинд үндэсний бичгээр хүүхдэд аюулгүй байх анхааруулах 5 төрлийн санамж боловсруулан байршуулсан. Хүүхэд хамгааллын тухай зөвлөгөө зөвлөмж 18 төрлийг	90%

						байгууллагын цахим хаяг болон ангийн групп дээр байршуулсан. Хүүхдэдээ зав гаргая аян 4 бүлгийн эцэг эхийн дунд зохион байгуулан 4 төрлийн шторк, 3 төрлийн видео контент боловсруулан цахим сүлжээгээр дамжуулан иргэд олон нийтэд хүргэж ажилласан байна.	
3.5	<u>Арга хэмжээ 3.5</u> Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт багш ажилчид хүүхдүүдийг хамруулах, эрүүлжүүлэх төлөвлөгөө гарган ажиллана.		Төлөвлөгөөний хэрэгжилтээр		Эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан Дархлаа дэмжсэн ажил зохион байгуулсан	Багш ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 8 дугаар сард 100% хамрагдсан. 9 дүгээр сард цагаан хорхойн шинжилгээнд 68 хүүхэд Биеийн ерөнхий үзлэгт 43 хүүхэд Томуу томуу -төст өвчний дархлаажуулалтад 36 хүүхэд Витамин А төрлийн витаминжуулалтад 59 хүүхэд Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран 4 бүлгийн 42 хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан өвчлөлийн талаар эцэг эх асран хамгаалагчид мэдээлэл өгч эрүүлжүүлэх ажлыг сумын эрүүл мэндийн төвтэй хамтран үе шаттай зохион байгуулан ажиллаж байна.	100%
3.6	<u>Арга хэмжээ 3.6</u> Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн газрын эрүүл ахуй, ариун цэвэр,		Оролцоо		2024 онд 80%	Хүүхдийн хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуй стандартын шаардлага хангах чиглэлээр дотоод хяналт шалгалтын үйл	90%

	стандартыг хангах ажлуудыг зохион байгуулах					ажиллагаагаар хяналт тавьж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Хоол амталгааг эцэг эхчүүдэд тухай бүр болон зориудаар амтлуулах үйл ажиллагааг 7 хоног бүр, жижүүр багш хоолны амт чанар хоолны хүрэлцээ хангамжийн талаар өдөр бүр тэмдэглэл хөтөлж ажиллаж байна. Тогооч Т.Нямыг Арвайхээр суманд зохион байгуулагдсан тогооч нарыг чадавхжуулах 2 өдрийн сургалтад хамруулсан. Өвөрхангай аймгийн нийтийн хоолны тогооч нарын ур чадварын уралдаанд 1 тогооч амжилттай оролцсон	
3.7	<u>Арга хэмжээ 3.7</u> Хүүхдийн хоол, хүнсний аюулгүй байдал, хоолны нэр төрлийг олшруулах, илчлэг шим тэжээлийг тогтоох.		Хэрэгжилтийн түвшнээр		Хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.	Хүүхдийн хоол хүнсний хадгалалт хамгаалал, нэр төрлийг технологийн картын дагуу илчлэг нормыг тооцож ажилласан Хоолны нэр төрлийг олшруулан 14 хоногт давтагдахгүй байхаар хувиар гаргаж байна. Өдөрт 1 аяга сүү хөтөлбөрийг хэрэгжүүлэн 7 хоногт 1 удаа хөөрүүлсэн сүү өгч хэвшсэн	90%
3.8	<u>Арга хэмжээ 3.8</u> “Эрүүл шүд, эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах.		Өвчилсэн шүдтэй хүүхдийн тоогоор	Жилдээ		2-5 насны 36 хүүхдэд шүдний үзлэгт хамруулан эрүүлжүүлэх ажлыг эцэг эхтэй хамтран зохион байгуулсан 11 сарын байдлаар Сумын эрүүл	90%

						мэндийн төвтэй хамтран 4 бүлгийн 42 хүүхдэд шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан өвчлөлийн талаар эцэг эх асран хамгаалагчид мэдээлэл өгч эрүүлжүүлэх ажлыг сумын эрүүл мэндийн төвтэй хамтран үе шаттай зохион байгуулан ажиллаж байна.	
<b>ЗОРИЛТ 4 : БАГШ, АЖИЛТНЫ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>							
4.1	<u>Арга хэмжээ 4.1</u> Хүний нөөцийн бодлогын хэрэгжилт		Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийг гүйцэтгэлээр нь		2023 оны төлөвлөлтийн гүйцэтгэлээр хэрэгжүүлж байгаа	Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд анхаарч багш ажилчдын сурах мэргэжил дээшлүүлэх чиглэлээр тогтмол мэдээлэл өгч ажиллахаас гадна мэргэжлийн бус 1 багш байсныг үндсэн мэргэжлийн багшаар хангаж 100% мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байна. Цаашид 2 багшийн туслахыг бүлгийн багшаар сургаж боловсон хүчнээ бэлтгэх ажил эхэлсэн байна.	100%
4.2	<u>Арга хэмжээ 4.2</u> Багшийн цахим кампус оффис 360, мэдлээ.мн зайны сургалтын системийг хөгжүүлж багш нарын 90-ээс доошгүй хувийн мэргэжил боловсролыг дээшлүүлнэ		Багш нар цахим технологи ашиглаж сурсан багшийн тоогоор		Багш нар захиалгат сургалтад хамрагдаагүй байсан	Medle 100 оффис 360 зэрэг хэрэглээний программыг өдөр тутмын хэрэглээндээ ашиглан өөрсдийн ажлын үр дүнг сайжруулан ажилласан	100%

4.3	<p><u>Арга хэмжээ 4.3</u> Улс, аймаг, орон нутгийн чанартай мэргэжил дээшлүүлэх, чадавхжуулах сургалтуудад багш, ажилтнуудыг тасралтгүй хамруулна. /цахим, танхимын/</p>		Сургалтад хамрагдсан багш, ажилтнуудын тоогоор		2023 онд 3-н багш хамрагдсан	2024 онд 4-н багш, эрхлэгч 1 нийт 10 удаагийн сургалтад хамрагдсан байна.	100%
4.4	<p><u>Арга хэмжээ 4.4</u> Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгаа хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулж, албан хаагчдын үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэлээр дүгнэх</p>		Хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал Байгууллагын ёс зүйн дэд зөвлөл, дотоод хяналт шалгалтын ажлын чанар		2023 онд төлөвлөгөөнд тусгагдсан ажил 85% тай хэрэгжсэн	<p>Багш ажилтны сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 5 төрлийн үйл ажиллагаагаар хэрэгжүүлэн ажилласан Нийт гарсан зардал чадавхжуулах сургалтад 2 ажилтан 600,000 төг Туршлага судлах үйл ажиллагаа 350,000 төг Бүсийн арга хэмжээнд 250,000 төг Тогооч нарын ур чадварын уралдаанд 200,000 төг улсын төсөв болон сум орон нутгийн дэмжлэгээр шийдвэрлэсэн байна. Гэр нь шатсан 1 албан хаагчид 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгосон</p>	90%
4.5	<p><u>Арга хэмжээ 4.5</u> Оны эцэст байгууллагын шилдэг тэргүүний ажилтнуудыг тодруулан урамшуулна.</p>		Төлөвлөгөөний биелэлт, ёс зүйн дүрмийн хэрэгжилтээр		2023 онд Багш, туслах багш, ажилтан шалгарсан..	Эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэсэн Ажилтны бүлгийн багш 1, туслах багш 2, ажилтан 2-г хамт олны хурлаар хэлэлцэн	100%



						шалгаруулж оны аварга багш ажилтнаар тодруулан урамшуулсан. Нийт урамшуулсан зардлын хэмжээ 250,000 төг болсон	
4.6	<u>Арга хэмжээ 4.6</u> Ажлын байранд мэргэжил дээшлүүлэх, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх сургалтыг мэргэжлийн чиглэл бүрээр зохион байгуулна.		Сургалтын тоо, хамрагдсан багш ажилчдын тоогоор		4 удаа сургалт явуулж 100% хамрагдсан	12 удаа сургалт явуулж 90% хамруулсан байна Хүүхэд хамгаалын шинэчлэн хууль танилцуулах сургалт багш ажилтанд 1 удаа, эцэг эхийн нийтийн хурлаар 1 удаа, Ёс зүйн дүрмийн сургалтын 2 удаа нийт 21 багш албан хаагчид Хувилбарт сургалт зохион байгуулах сургалтын 1 нийт давхардсан тоогоор Ажлын байран дээрээ чадважжуулах 4удаагийн цахим сургалтад нийт 4 багш ажилтан тус тус хамрагдсан байна.	90%
4.7	<u>Арга хэмжээ 4.7</u> Багш ажилчдыг урьдчилан сэргийлэх шинжилгээ эрт илрүүлэлтийн үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах		Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан байдал, эрүүлжүүлсэн арга хэмжээний чанар, үр дүнгээр		2023 онд бүрэн хамруулсан	Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог БОЭТ хамтран 100% хамруулсан. Нийт 700,000 төгрөгийн зардал гарсан.	100%
4.8	<u>Арга хэмжээ 4.8</u> Багш ажилчдын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт		Зохион байгуулсан ажлын чанар, үр дүнгээр			Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг суулгах, эрүүл идэвхтэй амьдралыг дэмжих чиглэлээр өглөө 7.30 минутад ирж Дасгал хөдөлгөөн хийхээс	90%

	сургах зорилго бүхий ажлуудыг зохион байгуулна					гадна спорт зааланд 14 хоногт 1 удаа заал авч тоглосон. Марафон гүйлтийн уралдаанд баг хамт олноороо амжилттай оролцсон. Сум орон нутгаас зохион байгуулсан 4 удаагын спортын арга хэмжээнд амжилттай оролцсон	
<b>ЗОРИЛТ 5: СУРГАЛТЫН ОРЧИН БҮДҮҮЛЭЛТ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>							
5.1	<u>Арга хэмжээ 5.1</u> Сургалтын хөтөлбөрийн менежмент, сургалтын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа хангах.		Хэрэгжилтийн үр дүнгээр	Жилдээ	80 хувь	Хүүхэд хөгжүүлэх сургалтыг чанарыг сайжруулах талаар 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ зохион байгуулах Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах Сургалт үйл ажиллагааг чанартай зохион байгуулах талаар бүлгийн багш нарт сургалт мэдээлэлийг ажлыг 8 удаагын үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	100%
5.2	<u>Арга хэмжээ 5.2</u> Сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, зохион байгуулалт		Сургалтын төлөвлөлт, хэрэгжилтийн үр дүнгээр	Жилдээ	Төлөвлөлтийг цаасаар болон цахимаар хэрэгжүүлсэн	Сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт зохион байгуулалт шинэчлэлд 7 хонгийн 5 өдөр баталгаажуулан хэрэгжилтэд хяналт тавин ажилласан ажлуудыг зохион байгуулан ажилласан	90%
5.3	<u>Арга хэмжээ 5.3</u> Хүүхдийн түвшинд тохирсон гарын авлагыг		Гарын авлагын тоогоор		2023 онд 60 хувь	Хүүхдийн сургалт үйл ажиллагаанд ашиглах ном гарын авлага 130ш	100%

	сар, улирал бүр нэмэгдүүлж, сургалтад ашиглах, номын сангийн фондыг нэмэгдүүлэх					боловсруулсан өдөр дутам орох сургалт үйл ажиллагааны хэрэглэгдэхүүнийг хийж үйл ажиллагаандаа ашигласан. Нийт 200 гаруй төрлийн хэрэглэгдэхүүн гарын авлага бэлтгэсэн байна. 9 дүгээр сард 4 бүлгийн номын төвд нийт 100 гаруй ном гарын авлага орчны хамт баяжилт хийсэн.	
<b>ЗОРИЛТ 6: УДИРДЛАГЫН МАНЛАЙЛАЛ, БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ, ИРГЭД ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>							
6.1	<u>Арга хэмжээ 6.1</u> Төрөөс иргэдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг төрийн хангаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах		Хуулийн хэрэгжилт, ил тод байдлын үзүүлэлт	-	СӨББ-н хамран сургалт өсөж хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ 20%-иар өсөх	Шинээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт болох хүүхэд хамгаалал эцэг эх олон нийтэд хүргэх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан 17 мэдээлэл хүргэсэн байна. Сумын иргэдэд СӨББ-н үйл ажиллагааг танилцуулах ажлыг 1 удаа Хувилбарт сургалтыг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар эцэг эх асран хамгаалагчийн уулзалтыг тус тус зохион байгуулсан байна. Иргэдээс СӨББ-н үйл ажиллагааны талаар санал асуулга 1 удаа авч үр дүнг багш ажилтанд танилцуулан үйл ажиллагаандаа тусгаж ажилласан	100%

6.2	<u>Арга хэмжээ 6.2</u> Байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлж, мэдээллийг тухай бүр байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байрлана		Хэрэгжсэн үйл ажиллагааны тоогоор		Үйл ажиллагааны тоо өсч чанар тодорхой хуваар өссөн байна	Байгууллагын нээлттэй ил тод байдлыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, шуурхай чирэгдэлгүй байх арга хэмжээг авч ажиллалаа Цахим тендер шалгаруулалт ажилтан авах зэрэг зар мэдээллийг олон нийтийн сүлжээгээр дамжуулан хүргэж ажилласан.	100%
6.3	<u>Арга хэмжээ 6.3</u> Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн захиргааны төв байгууллагуудад асуудал тавихдаа журмын дагуу аймгийн удирдлагуудад хүргүүлж ажиллана.		Хуулиар олгосон эрхийн хүрээний асуудлаар хандсан эсэх Холбогдох дүрэм, журмыг зөрчөөгүй байх		Ямар 1 дүрэм зөрчсөн үйл ажиллагаа гараагүй байна.	Хууль тогтоомжийн хүрээнд ажилласан	100%
6.4	<u>Арга хэмжээ 6.4</u> Ажлын байранд мэргэжил дээшлүүлэх, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, хандлагыг өөрчлөх сургалтыг мэргэжлийн чиглэл бүрээр зохион байгуулна.		Сургалтын тоо, хамрагдагсан багш ажилчдын тоогоор		4 удаа сургалт явуулж 100 хувь хамрагдсан	Ажлын байран дээрх 7 удаа сургалт явуулж 100% хамруулсан ЗАН-н ажлын журамнд сурах, өөрийгөө хөгжүүлэх зэргийг тусгасан цагийн хувиарийг оруулж өгсөн	90%
6.5	<u>Арга хэмжээ 6.5</u> Багш ажилтануудын мэргэжлийн чадавх, ёс зүйн хэм хэмжээ, харилцааны талаар санал асуулгыг эцэг эхээс авч дүгнэлт гаргаж ажиллана.		Санал асуулгын үр дүнгээр			1 удаа санал асуулга авч дүгнэн бүлгийн багш нарт танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.	90%

6.6	<u>Арга хэмжээ 6.6</u> Байгууллагын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр хийлгэн үнэлүүлж, түүнд тулгуурлан цаашид авах арга хэмжээг төлөвлөх		Ажлын үр дүн, гүйцэтгэлээр		70 хувь	Байгууллагын өөрийн үнэлгээ 803 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.	70%
6.7	<u>Арга хэмжээ 6.7</u> Эцэг эх асран хамгаалагч, багш ажилтнуудад хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт зохион байгуулна.		Сургалтын тоо, гүйцэтгэлээр		90 хувь	Хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэд хамгаалал гэж юу вэ? Сургалтуудыг 67 эцэг, эх, асран хамгаалагчид зохион байгуулсан	90%
6.8	<u>Арга хэмжээ 6.8</u> Цахим хэлбэрт шилжсэн төрийн үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, цахимаар үйлчилгээ авах иргэдийн тоог нэмэгдүүлэх		Сурталчлан таниулах хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээр		Үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулсан	Цахимаар хүүхдийн өдрийн хоолны мэдээлэл, элсэлт төгсөлттэй холбоотой мэдээллийг эцэг эх, асран хамгаалагчдыг мэдээллээр хангаж ажилласан.	90%
<b>ЗОРИЛТ 7: БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР</b>							
7.1	<u>Арга хэмжээ 7.1</u> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, Төрийн худалдан авах ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх		Цахимаар зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тоо, цахим дэлгүүрээс худалдан авалт хийсэн тоо		-	Худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулсан хэдий ч тендер шалгаруулалт цуцлагдан дахин зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	70%

7.2	Арга хэмжээ 7.2 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээлэл байршуулалтын чанарыг сайжруулах		Мэдээлэл байршуулалт мэдээ илгээлт (хувиар)		2022 онд 144-н мэдээлэл орохоос 142 мэдээ орж 98 хувийн гүйцэтгэлтэй.	2024 онд мэдээлэл 3 мэдээлэл хоцроосон 93%-н хэрэгжилттэй ажилласан.	100%
7.3	<u>Арга хэмжээ 7.3</u> Батлагдсан төсөвт багтаан, төсвийг үр өгөөжтэй, өр авлага үүсгэхгүй зарцуулна.		Төсвийн хуваариар		2023 онд гүйцэтгэл 100 хувь	2024 оны бүтэн жилийн байдлаар төсвийн хэрэгжилт Улсын төсөв 510,955,900 Гүйцэтгэл 412,464,363.12 Үлдэгдэл 98,491,536, Орон нутгийн төсөв 35,125,400 Гүйцэтгэл 33,313,124.86 Төвлөрүүлэлт 1,812,275.14 , Төсвийн нийт гүйцэтгэл 94.8% биелэлттэй хэрэгжсэн байна	100%
7.4	<u>Арга хэмжээ 7.4</u> Жилийн эцсийн аудитын шалгалтаар зөрчилгүй санал дүгнэлттэй ажиллана.		Шалгалтын дүнгээр		Зөрчилгүй гаргахгүй ажилласан.	Аливаа төрлийн зөрчил үүсгээгүй байх дээр анхааран ажлуудыг төлөвлөн ажилласанаар зөрчилгүй дүгнэлттэй гарсан	100%
7.5	<u>Арга хэмжээ 7.5</u> Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулах		Багш ажилчдын тоогоор төлөвлөлт хэрэгжилт хяналтаар		Хүний нөөцийн мэдээллийн санг цалингийн нэгдсэн системтэй холбож ажилласан.	Мэдээллийн нууцын гэрээ байгуулан багш ажилтан албан хаагчийн мэдээ мэдээллийг цаг тухай бүр шинэчлэн оруулж үнэн зөв мэдээлэл байршуулан ажилласан байна	100%
7.6	Арга хэмжээ 7.6 Санхүүгийн мэдээ мэдээллийг "Санхүүгийн ил тод байдлын самбар"-		Мэдээ мэдээлэл шинэчлэгдсэн, тайлан гарах		2023 онд орлого зарлагын баримт 100 хувь тавигдсан	2024 он бүтэн жилийн мэдээ тайлан, орлого зарлагын баримт гарах бүр самбарт тавьж 100% байршуулсан.	100%

	аар эцэг эх, олон нийт, багш ажилчдыг бүрэн хангана.		бүр, орлого зарлагын баримт бичих бүр.				
7.7	<u>Арга хэмжээ 7.7</u> Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, орон нутгийн өмчийн талаар мөрдөгдөж байгаа хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах		Тайлант онд шинээр бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгасан хувь			Цалин санхүүжилттай холбоотой шинээр гарсан хууль, журмыг 100% хэрэгжүүлэн ажиллаж байна Шинээр 4ш нөтбүүк Орон нутгийн хөгжлийн сангаар санхүүжүүлсэн агуулахыг хөрөнгөд бүртгэж авсан.	100%
Ерөнхий дүн						89%	

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ХЯНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

ЗАСАГ ДАРГА

/.../

Ц.МЯГМАРСҮРЭН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН: ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

Тэмдэг

ЭРХЛЭГЧ  
/албан тушаал/



Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2024-12-17